

ШИХИХУТУГ

Цуврал 34, Дугаар 1, 2026 оны 4 сар, Хуудас 16-32
<https://shu.edu.mn/journal>



ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН,
ТӨРИЙН ШАГНАЛТ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ
УХААНЫ ДОКТОР (S.C.D), ПРОФЕССОР,
ШУА-ИЙН ЖИНХЭНЭ ГИШҮҮН, АКАДЕМИЧ
СОДОВСҮРЭНГИЙН НАРАНГЭРЭЛ ТАНД
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ЗЭРГИЙН
“ЧИНГИС ХААН” ОДОН ХҮРТСЭНД ХАЛУУН
БАЯР ХҮРГЭЕ.

ШИХИХУТУГ ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ХАМТ ОЛНООС

2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ-1

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн зарлигаар Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 863 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан академич Содовсүрэнгийн Нарангэрэлд төрийн дээд шагнал болох “Чингис хаан” тэргүүн зэргийн одон хүртлээ.

ШХИС-ийн хүндэт доктор, ШУА-ийн жинхэнэ гишүүн, академич, төрийн шагналт, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Содовсүрэнгийн Нарангэрэл багш маань “Чингис хаан” тэргүүн зэргийн одон хүртсэн явдалд талархал илэрхийлж, 2025 оны 11 сарын 21-ний өдөр Шихихутуг их сургуулийн эрдмийн хамт олон хүндэтгэл үзүүлж хүлээн авлаа.

Арга хэмжээний үеэр Академичид хүндэтгэл үзүүлж, Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга доктор (Sc.D), профессор Д.Лүндээжанцан, Шихихутуг их сургуулийн ууган төгсөгчдийн төлөөлөл Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Д.Отгонтуяа нар талархлын үг хэлж, Шихихутуг их сургуулийн ректор, профессор Д.Оюунцэцэг дурсгалын зүйл гардууллаа.

Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга доктор, профессор Д.Лүндээжанцан хэлсэн үгэндээ “Монгол Улсын төрийн дээд шагнал болох “Чингис хаан” тэргүүн зэргийн одонгоор шагнагдсан эрхэм хүндэт академич Содовсүрэнгийн Нарангэрэл Танд Шихихутуг их сургуулийн хамт олон, үе үеийн төгсөгчид, багш, судлаачдын нэрийн өмнөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэж, гүн талархал илэрхийлье. Энэ эрхэм хүндтэй шагнал нь зөвхөн нэгэн эрдэмтний амжилтыг үнэлсэн хэрэг бус, Монголын хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүйн боловсрол, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд зориулсан хагас зуунаас илүү хугацааны уйгагүй хөдөлмөр, бүтээлч сэтгэлгээ, эх оронч зүтгэлийн бодит үнэлгээ юм.

Академич С.Нарангэрэл Та Монгол Улсад ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааг төлөвшүүлэх, шинэ эрх зүйн тогтолцооны онолын суурийг бэхжүүлэх, хууль зүйн нэр томьёо, эрх зүйн сэтгэлгээ, үндэсний эрх зүйн боловсролын хөгжлийг шинэ шатанд гаргахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ. Таны туурвисан бүтээлүүд зөвхөн хуульчдын ширээний ном болоод зогсохгүй монгол хүний төрт ёс, ёс суртахуун, шударга ёсны тухай ойлголтыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн оюуны үнэт өв болсон юм.

Ялангуяа Их эзэн Чингис хааны төр, эрх зүй, ёс суртахууны үзэл санааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, дэлхий дахинд сурталчлан таниулсан Таны бүтээлүүд нь Монголын түүх, соёл, төрт ёсны үнэ цэнийг олон улсад түгээн дэлгэрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ.

Шихихутуг их сургууль нь Монголын хууль зүйн боловсрол, үндэсний эрх зүйн уламжлалыг эрхэмлэн хөгжүүлэх зорилготойгоор байгуулагдсан бөгөөд энэ эрхэм зорилгын нэгэн оюуны тулгуур, үлгэр дуурайл болсон хүн бол академич С.Нарангэрэл Та мөн юм.

Таны шавь нар өнөөдөр төрийн байгууллага, шүүх, прокурор, өмгөөлөл, хууль сахиулах байгууллага, эрдэм шинжилгээ, боловсролын салбарт үр бүтээлтэй ажиллаж, Монгол төрийн хууль ёс, шударга ёсны үйл хэрэгт хүчин зүтгэж байна. Энэ бол багш хүний хамгийн том бахархал, хамгийн үнэ цэнтэй өв мөн.

Таны хөдөлмөр бүтээл, эрдэм судлалын замнал нь монгол хуульчдын үе үеийн төлөөлөлд үлгэр дуурайл болсоор байх болно гэдэгт бид итгэл төгс байна.

Эрхэм хүндэт академичдаа, Монголын хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын салбарт оруулсан гавьяа зүтгэлийн тань төлөө дахин халуун баяр хүргэж, эрүүл энх, урт удаан насалж, эрдэм судлалын их үйлс тань улам арвижин дэлгэрэхийн ерөөлийг өргөн дэвшүүлье хэмээн онцолсон.

Багш дор мөргөм үү.

---oOo---

Scott J. Shapiro

LEGALITY



Редактор: Д.Лүндээжанцан доктор
(Sc.D), профессор

Орчуулсан: С.Энх-Амгалан хуульч,
орчуулагч

2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ-2

Шихихутуг их сургуулийн “Дэлхийн оюуны өвийг Монголд” санаачилгын хүрээнд дэлхийн нэрт эрх зүйч, философич Йелийн их сургуулийн профессор Скотт Ж.Шапирогийн “Legality” бүтээлийг “Хуульт ёс” нэрээр монгол хэлнээ орчуулан хэвлүүлж, албан ёсны нээлтийн арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр зохион байгууллаа.

Энэхүү бүтээл нь орчин үеийн эрх зүйн философи, онолын хамгийн нөлөө бүхий судалгааны нэг бөгөөд хууль гэж юу вэ, хууль хэрхэн үүсэж хөгждөг, нийгэмд ямар үүрэгтэй вэ гэдгийг гүнзгий шинжилсэн академик бүтээл юм. Дэлхийн олон их сургууль, судалгааны байгууллагуудад уг номыг эрх зүйн онолын суурь эх сурвалж болгон ашигладаг байна. Номын монгол хэлээр орчуулгыг хуульч, орчуулагч С.Энх-Амгалан хийж, орчуулгын редактораар Шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан ажилласан бөгөөд Монгол Улсын Их Хурлын Тамгын газар зохиогчийн эрхийг авч, хэвлэлийн ажлыг Шихихутуг их сургуультай хамтран хэрэгжүүлсэн.

Номын нээлтийн арга хэмжээнд Монголын хууль зүйн салбарын эрдэмтэн судлаачид, их сургуулийн багш нар, хуульчид, оюутнууд оролцсон бөгөөд номын зохиогч, профессор Скотт Ж.Шапиро Монголын уншигчдад зориулан мэндчилгээ дэвшүүлж, УИХ-ын Тамгын газрын дэд дарга доктор (Ph.D) Г.Эрдэнэбат, ДХИС-ийн зөвлөх профессор доктор (Ph.D), профессор, Ч.Нямсүрэн, Шихихутуг их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор (Ph.D), профессор Г.Амаржаргалан нар талархлын үг хэллээ.

Уг арга хэмжээний үеэр талархал илэрхийлсэн ДХИС-ийн зөвлөх профессор доктор (Ph.D), профессор, Ч.Нямсүрэн, Шихихутуг их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор (Ph.D), профессор Г.Амаржаргалан нарын талархлын үг болон редакторын бүтээлд зориулан тэрлэсэн өмнөх үгийг та бүхэнд толилуульж байна.



РЕДАКТОРЫН ӨМНӨХ ҮГ

(Номоос төрсөн сэтгэгдэл)

Д.Лүндээжанцан, доктор (Sc.D), профессор

Энэхүү өмнөх үгээрээ С.Шапирогийн Legality буюу Хуульт ёс номын талаарх эргэцүүлээ толилуулж байна. Уг бүтээл эрх зүйн онолд оюун бодлоо чилээж буй хэн бүхэнд ямар асуулт тавьж, юуг тодруулж, юуг улам төвөгтэй болгож байгааг илэрхийлэхийг зорилоо.

1. Удиртгал

Скотт Шапирогийн 2011 онд олны хүртээл болгосон Хуульт ёс (Legality) номыг уншихад нэг талаас бахархах сэтгэгдэл төрөхийн зэрэгцээ, нөгөө талаас эргэлзэж тээнэгэлзэх мэдрэмж төрдөг. Шапирогийн бүтээлийн үнэ цэн нь эрх зүйн мөн чанарыг төлөвлөлтийн үүднээс системтэй, зоримог байдлаар тайлбарлах оролдлогод оршино. Тэрээр өмнөх онолуудыг шүүмжлэхээс илүүтэй маргаан, төвөгтэй байдлын дундах хүний хамтын ажиллагааг илүү өргөн хүрээнд тайлбарлах зорилгын дор эдгээр онолуудыг дахин авч үзсэн байна.

Шапиро эрх зүйг нэгдсэн, ойлгомжтой байдлаар тайлбарлаж чадсан нь үнэхээр ололт юм. Тэрээр хууль бол зүгээр нэг тушаал юм уу эсхүл ёс суртахууны төгс шийдвэр байх албагүй, харин хүмүүсийн хамтын ажиллагааг төлөвлөгөөний тусламжтайгаар зохицуулах арга хэрэгсэл юм гэдгийг тодорхой тайлбарласан байдаг. Энэ үзэл санаа нь эрх зүйн институцуудын үүрэг, бүтэц, ач холбогдлыг ойлгоход онцгой тустай. Гэхдээ энэ нь эрх зүйн арай илүү өргөн хүрээний шударга ёс, сайн сайхны төлөөх зорилгыг хэтэрхий бага үнэлж байна уу гэсэн бодол төрүүлж байна. Хуулийг зөвхөн төлөвлөгөө болгон ойлгосноор түүний ёс суртахууны өндөр зорилго бүхий шинж чанарууд бүдгэрч болох эрсдэлтэй юм биш үү?

Шапирогийн хэлдгээр түүний онол нь "эрх зүй ямар байх ёстойг" биш, харин "эрх зүй гэж юу вэ" гэдгийг л тайлбарлах зорилготой байдаг. Гэхдээ бодит байдал дээр энэ хоёр ойлголтыг бүрэн тусгаарлах боломжгүй байж болох талтай. Хуулийг төлөвлөгөө гэж ойлгох нь хуулийн сайн мууг хэрхэн үнэлэхэд бидэнд нөлөөлөх нь гарцаагүй юм.

Эрх зүйн ерөнхий онолын үүднээс эрх зүй ба төрийг авч үзэхэд хүний нийгэм буй болоход л тэнд үүссэн харилцааг зохицуулагч эрх зүй бий болсон. Энэ үзэл баримтлалын онолын уг үндэс нь төрөлх (жам ёсны) эрх зүйн онол болох тухай бид ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас эхлэн ярьж, хичээл зааж, бичиж ирсэн байдаг. Харин нийгмийн хөгжлийн тодорхой шатанд төр бий болсон. Төр нь нийгэмд бодитой оршиж, үйлчилж буй хэм хэмжээг олж хуульчлах үүрэг хүлээдэг. Төрөөс тогтоосон хэм хэмжээг цогцоор нь позитив эрх зүй хэмээн нэрлэдэг.

Хамгийн энгийнээр тайлбарлахад "байх ёстой", "байгаа"-ийн зөрчил буюу зөрүү хамгийн бага байвал хууль тогтоогч үүргээ сайн биелүүлж байгаа үзүүлэлт болно. Харамсалтай нь бодит байдал дээр гол төлөв л тийм бус байдаг гэж судлаачид онцлон тэмдэглэсэн нь олонтаа. Тэгэхлээр эрх зүйн ерөнхий онолын тулгуур нь жам ёсны эрх зүйн онол, эрх зүйн позитивизм хоёр юм. Энэ хоёрын сөргөлдөөнийг та энэ номоос тодруулан унших болно.

Авлига, эрх мэдлийг буруугаар ашиглах, авторитар тогтолцооны асуудалтай тулгарч буй нийгэмд Шапирогийн онол хоёр талтай. Нэг талаас энэ онол нь алдаатай ч гэсэн дүрэм журмыг яагаад дагах ёстойг ойлгуулахад тусалдаг бол, нөгөө талаас сайн төлөвлөж чадвал шударга бус тогтолцоог ч зөвтгөх эрсдэлтэй мэт харагдаж болно.

Хуульт ёс бүтээлийг унших нь оюуны томоохон сорилт бөгөөд эрх зүйг зүгээр нэг хатуу дэг журам, ёс суртахууны үүрэг хариуцлага хүлээлгэсэн дүрмийн цуглуулга биш, харин нийгмийн төлөвлөгөөт хамтын ажиллагааны динамик үйл явц юм гэж шинээр эргэцүүлэхэд хүргэж байна.

АНУ-ын Йелийн их сургуулийн профессор Шапирогийн энэ ном сүүлийн үед эрх зүйн онолын чиглэлээр гарсан хамгийн дорвитой бүтээл юм.

2. Эрх зүйг тодорхойлох нь асуудалтай

Хуульт ёс ном нь "Эрх зүй гэж юу вэ?" гэсэн энгийн мэт боловч чухал асуултаар эхэлдэг. Шапиро энэ асуултыг зүгээр л онолын асуудал гэж үздэг хүмүүст түүний ач холбогдлыг тайлбарласан байна: эрх зүйн мөн чанарыг ойлгох нь эрх мэдэл, үүрэг хариуцлага, хуулийг тайлбарлах арга барилыг тодорхойлдог учраас, хууль, эрх зүйн практикт зайлшгүй чухал гэжээ.

Энэ нь хуулийн тайлбарууд зөрчилдөж, хэрэглээ нь тогтворгүй байдаг эрх зүйн тогтолцоонд маш чухал нөлөөтэй юм. Хэрэв хуулийг зөв ойлгохгүй бол түүнийг яагаад дагах ёстойг эсхүл хэрхэн шүүмжлэхийг зөвөөр тайлбарлах боломжгүй. Энд Шапирогийн санаа маш тодорхой харагдаж байна: эрх зүйн үндсэн ойлголтуудыг судлах нь зүгээр нэг хийсвэр ажил биш харин хууль зүйн үндэслэлийг бат бөх болгоход зайлшгүй шаардлагатай. Тэрээр аливаа онол тайлбарлах ёстой ерөнхий үнэнүүд (truisms) буюу эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шинж чанаруудыг онцлон тэмдэглэсэн нь онолын хэлэлцүүлэгт өндөр стандарт тогтоож байна.

Гэсэн хэдий ч эдгээр "нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн" шинж чанарууд Шапирогийн хэлснээр үнэхээр тийм түгээмэл үү гэдэг нь эргэлзээтэй. Учир нь хууль, эрх зүйн олон талт байдал, соёлын ялгаа нь нэг тогтолцоонд онолчдод "илэрхий" санагдах зүйл өөр газар огт өөр байж болохыг харуулдаг. Гэхдээ түүний арга барил нь эрх зүйн онолууд өөрсдийн тайлбарлах чадварыг батлах ёстой гэсэн зөв шаардлагыг тавьсан байна.

3. Эрх зүй бол нийгмийн төлөвлөлт

Энэ номын хамгийн чухал санаа бол Шапирогийн дэвшүүлсэн Эрх зүйн төлөвлөлтийн онол (Planning Theory of Law) юм. Тэрээр өмнөх онолууд (жишээ нь Остиний шийтгэлийн онол)-ыг хэтэрхий энгийн, учир дутагдалтай гэж үзсэн. Харин Шапирогийн онолоор бол хууль гэдэг нь хүмүүсийн хооронд үүсдэг хамтын ажиллагааны асуудлыг шийдэхийн тулд бий болсон нийгмийн хамтын төлөвлөгөө юм. Хууль нь хүмүүсийг зүгээр л шийтгэлээр сүрдүүлж, албадах бус, харин янз бүрийн үзэл бодолтой, олон хүнтэй нийгэмд хоорондоо зөв зохицон амьдрахад тусалдаг хамтын төлөвлөгөө болж өгдөг гэж тайлбарласан байна.

Энэ санаа нь маш тодорхой бөгөөд ойлгоход хялбар юм. Эрх зүйг "төлөвлөгөө" гэж ойлгосноор эрх зүйн тогтолцоо (legal system)-нууд яагаад нарийн төвөгтэй байдлыг шийдэж, хүмүүсийн маргаан, ойлголтын зөрүүтэй байдлыг багасгаж чаддагийг тайлбарлаж өгдөг. Өөрөөр хэлбэл хүн бүр өөрийнхөөрөө юу хийхээ эхнээс нь бодож, эргэлзэхийн оронд нийгэм нийтээрээ дагаж мөрдөх тодорхой төлөвлөгөөг гаргадаг.

Ингэснээр хүмүүсийн ойлгомжгүй байдал арилж хамтын ажиллагаа илүү амар хялбар болдог.

Гэхдээ энэ үзэл нь зөвхөн хуулийн практик ач холбогдлыг харуулах төдийгүй, эрх зүйн институцууд ямар үүрэгтэйг илүү тодорхой болгож байна. Тодруулбал хууль тогтоогчид нь төлөвлөгөөг боловсруулагчид, шүүх нь тэр төлөвлөгөөг тайлбарлаж ойлгуулагчид, харин иргэд бол түүнийг өдөр тутамдаа хэрэгжүүлэгчид юм. Энэ утгаараа хууль (эрх зүй) нь ямар ч байгууллага, бүлгийн хамтын ажиллагааны бусад хэлбэртэй маш төстэй байдаг.

Гэвч хуульд байдаг ёс суртахуун, маргаан, зарчим зэрэг илүү нарийн, ээдрээтэй зүйлсийг бүгдийг нь зүгээр л “төлөвлөгөө” гэх үгээр бүрэн илэрхийлж чадах уу гэдэг асуулт урган гарч ирнэ. Шапиро энэ талаар номдоо тайлбарласан байна. Бүрэн тайлбар өгсөн эсэхийг та тунгааж үзээрэй.

4. Остин болон Хартын онолд өгсөн шүүмжлэл

Шапиро номын эхний бүлгүүддээ эрх зүйн позитивизмын алдартай төлөөлөгчдийн онолд шүүмжлэлтэй хандсан байна. Тэрээр Жон Остиний “санкцын онол”-ыг задлан шинжилж, энэхүү онол нь зөвхөн хүнийг сүрдүүлж, шийтгэдэг хуулийг тайлбарлаж чадах боловч, хүмүүст эрх, боломж олгодог хууль журмыг тайлбарлахдаа дутмаг гээд орчин үеийн эрх зүйн тогтолцоог зүгээр нэг "айлган сүрдүүлсэн тушаал" болгон харах нь буруу юм гэж үзжээ.

Харт эрх зүйн онолд оруулсан сайжруулалт буюу “анхдагч дүрэм” (primary rules буюу хүмүүсийн үйлдлийг зохицуулах дүрмүүд) болон “хоёрдогч дүрэм” (secondary rules буюу дүрмийг хэрхэн гаргах, өөрчлөх талаар зохицуулсан дүрмүүд)-ийг ялгасан нь Шапирогийн анхаарлыг татсан. Хартын “хүлээн зөвшөөрөх дүрэм” (rule of recognition) буюу хууль нь нийгмийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм байх ёстой гэсэн санааг Шапиро сайшаасан хэдий ч Харт энэ санаагаа цааш нь бүрэн хөгжүүлээгүй гэж үзжээ. Учир нь Харт хоёрдогч дүрмийн хэрэгцээг ойлгосон ч, эрх зүйн тогтолцоог өөрийн гэсэн төлөвлөгөө боловсруулах институт гэж хараагүй юм.

Шапирогийн шинэчилсэн тайлбар нь нэн үнэмшилтэй. Тэрээр эрх зүй бол нийгмийн бодит байдал гэсэн позитивист үзлийн үндсэн санааг орхилгүйгээр Хартын онолыг улам хөгжүүлсэн. Хүлээн зөвшөөрөх дүрмийг мета-төлөвлөгөө буюу төлөвлөгөөнүүдийн тухай төлөвлөгөө гэж өргөн хүрээнд харж, эрх зүйн онолыг илүү тодорхой тайлбарлаж өгсөн.

Шапиро эрх зүйн позитивист үзлийн хүрээнд тууштай байр суурьтай байгаа нь тодорхой харагдаж байна. Тэрээр эрх зүйн эрх мэдэл нь ёс суртахууны зөв байдалд бус харин нийгмийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэхэд хэр үр дүнтэй байгаагаар тодорхойлогддог болохыг харуулахыг зорьжээ.

5. Төлөвлөлтийн онолыг дэлгэрэнгүй тайлбарлах нь

Шапиро онолоо номынхоо дунд хэсэгт илүү дэлгэрүүлэн тайлбарласан байдаг. Түүний тайлбарласнаар бол эрх зүйн дүрмийг хүмүүсийн хамтран мөрддөг төлөвлөгөө гэж ойлгох нь хамгийн зөв юм. Эдгээр төлөвлөгөө нь хүмүүсийн дунд үүсэх маргаан, тодорхойгүй байдлыг багасгаж, хэн юу хийхийг урьдчилан тодорхой болгож өгдөг.

Тэрээр "төлөвлөгөөний шийдвэрлэх үүрэг" буюу “"тогтворжуулалт - settlement” гэх санааг онцолдог. Энэ нь хүмүүс тухайн хуулийг ёс суртахууны хувьд зөв эсэхтэй нь

санал нийлэхгүй байсан ч яагаад дагаж мөрдөх ёстойг тайлбарладаг. Өөрөөр хэлбэл янз бүрийн үзэл бодолтой, олон талт нийгэмд хүн бүртэй санал нийлэх боломжгүй ч гэсэн бүгдийг зохицуулсан нийтлэг төлөвлөгөө байдаг учраас хүмүүс зөрчилд орохгүйгээр хамтран ажиллах боломжтой болдог.

Энэ үзэл санаа нь эрх зүйн олон онцлогийг ойлгоход тусална. Тухайлбал хууль нь нийтлэг шинжтэй байх, нийтэд нээлттэй байх, тогтвортой байх, бас эрх мэдэлтэй байх ёстойг тайлбарлаж өгдөг. Мөн хууль тогтоох, шүүн таслах ажиллагааны тухай нэмэлт дүрмүүдийг бусад төлөвлөгөөг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө болгон тайлбарладаг.

Гэвч шүүмжлэгчид энэ загвар нь хэтэрхий менежментийн шинжтэй байна гэж эсэргүүцэж магадгүй юм. Хуулийн зорилго нь зөвхөн зохион байгуулалт хийхээс илүү хүмүүсийг сайн сайханд чиглүүлэх, нийгмийг өөрчлөх зорилготой биш гэж үү? Ёс суртахууны хувьд шударга бус хуулийг шүүмжлэх боломж энэ онолд бий юу? гэсэн асуултууд гарч ирдэг. Шапиро энэ асуудлуудыг хүлээн зөвшөөрдөг боловч хуулийг нийгмийн төлөвлөгөө гэдгээр нь ойлгож байж л түүний хууль ёсны үндэслэлийг зөв ойлгож чадна гэж хамгаалсан байна.

6. Эрх зүйн тогтолцоо ба эрх мэдэл

Шапирогийн гол санаануудын нэг бол хуулийн тогтолцоо нь зөвхөн дүрмүүдийн цуглуулга биш харин нарийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж, хянах зорилготой институт гэсэн үзэл юм. Энэ утгаараа эрх мэдэл гэдэг нь нийгмийн асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг бий болгох чадвар юм.

Энэ шинэ хандлага нь хуулийг зөвхөн тушаал гэж хардаг байдлаас нь өөрчилж төлөвлөлт хийдэг институцийн үйл ажиллагаа гэж үзэхэд хүргэдэг. Шүүх, хууль тогтоох, захиргааны байгууллагууд нь зүгээр нэг дүрэм зохиогчид биш харин хүмүүсийн зан үйлийг зохицуулах үйл ажиллагаандаа амжилттай байснаар хууль ёсны болдог төлөвлөгчид юм.

Эрх мэдлийг ийм байдлаар тайлбарласнаар Шапиро нь хүмүүс хуулийн агуулгатай санал нийлэхгүй байсан ч яагаад хуульд дуулгавартай байх ёстой вэ гэсэн асуултад хариулдаг: учир нь нийтийн төлөвлөгөөнүүд нь нэг талын шийдвэр гаргахаас илүүтэйгээр хамтран ажиллах боломжийг олгодог.

Энэ функционал (үйл ажиллагаанд чиглэсэн) тайлбар нь анхаарал татам ч, нэг том эрсдэл бий: ямар ч үр дүнтэй төлөвлөгөөтэй системийг ёс суртахууны хувьд зөв үү, буруу юу гэдгээс нь үл хамааран зөвтгөж магадгүй. Шапирогийн позитивист (хууль бол ёс суртахуунаас ангид бодит зүйл гэх) байр суурь энд маш тодорхой харагддаг. Түүний хувьд хууль нь заавал ёс суртахууны хувьд зөв байх албагүй боловч хууль ёс суртахууны шүүмжлэлийг үгүйсгэдэггүй гэж үздэг.

7. Хэцүү кейсүүд ба хуулийг тайлбарлах асуудал

Шапиро номдоо “хэцүү кейс” буюу одоо үйлчилж буй хууль тогтоомж нь шийдвэрийг тодорхой гаргахад хангалтгүй байгаа нөхцөл байдлыг онцгойлон авч үздэг. Түүний хэлснээр ийм асуудлууд нь хуулийн алдаа, дутагдал биш, харин ямар ч төвөгтэй төлөвлөгөөт системд заавал гардаг ердийн үзэгдэл юм.

Хуулийг тайлбарлана гэдэг нь тухайн төлөвлөгөөний бүтэц болон зорилгыг харгалзаж уг төлөвлөгөө нь яг юуг шаардсан болохыг тодруулах үйл явц юм гэж тэр

тайлбарладаг. Шүүгчид энэ үед төлөвлөгөөний үндсэн утга санаанд үнэнч байж маргааныг зохицуулах анхны зорилгыг нь хүндэтгэх үүрэгтэй байдаг.

Энэ санаа нь шүүгч үргэлж ёс суртахууны хувьд хамгийн төгс шийдвэрийг эрэлхийлэх ёстой гэсэн үзлийг эсэргүүцдэг. Харин тайлбарлах үйл явц нь хуулийн үндсэн үүрэг буюу хүмүүсийн зөрчлийг багасгах хамтын төлөвлөгөөг баримтлахад төвлөрөх ёстой. Ингэснээр Шапиро нь хуулийг ёс суртахууны философийн нэг хэсэг мэтээр үздэг Дворкины онолыг эсэргүүцдэг.

Гэвч энэ нь дараах асуултуудыг үүсгэж байна: төлөвлөгөөнд үнэнч байхын тулд хэр хэмжээний эрх чөлөө шүүгчид хэрэгтэй вэ? Хэзээ бүтээлч тайлбар нь алдаа болох вэ? Шапиро эдгээр бэрхшээлийг хүлээн зөвшөөрдөг ч төлөвлөлтийн онол бол эрх зүйн тайлбар гэдэг нь юу болох тухай илүү шударга тайлбарыг санал болгодог гэж хамгаалдаг.

8. Дворкин ба итгэлийн асуудал

Хууль ёс номын онцгой анхаарал татдаг зүйл бол Рональд Дворкины онолтой хийсэн өргөн хүрээний хэлэлцүүлэг юм. Дворкин эрх зүйг шударга ёс, ёс суртахууны нэгдэл гэж үздэг бөгөөд энэ нь шүүгчдийн ёс суртахууны зөв шийдвэр гаргах чадварт хэт их итгэхэд хүргэдэг гэж Шапиро шүүмжилжээ.

Олон талт байдал буюу олон янзын хүмүүс амьдардаг нийгэмд иргэд зөвхөн эцсийн шийдвэр дээр биш, харин шийдвэр гаргах зарчмууд дээр ч хоорондоо санал зөрдөг. Ийм нөхцөлд шүүгчид "хамгийн зөв ёс суртахууны шийдлийг" олно гэж итгэх нь хэтэрхий их итгэл найдвар шаардаж байгаа хэрэг болно гэж тэр тайлбарласан байна.

Үүний оронд Шапирогийн төлөвлөлтийн онол нь хүмүүс хоорондын итгэлийг бага шаарддаг. Учир нь нийгмийн хамтын төлөвлөгөөний тусламжтайгаар хүмүүс ёс суртахууны асуудлууд дээр санал нэгдэхгүй байсан ч хоорондоо хамтран ажиллах боломжтой болдог. Энэ нь ёс суртахууны хувьд нэгдмэл ойлголтод хүрэх боломжгүй олон янзын нийгмийн бүлгүүдэд онцгой ач холбогдолтой юм.

Энэ нь хүчирхэг санаа бөгөөд судлаачдын анхаарлыг өөрийн эрхгүй татахаар байна. Учир нь энэ санаагаар эрх зүйн онолд улс төрийн нэгэн чухал асуудлыг тавьдаг. Тодруулбал ёс суртахууны хувьд адил тэгш эрхтэй боловч санал зөрөлдсөн хүмүүсээс бүрдэх нийгэмд ямар төрлийн эрх мэдлийн бүтэц хамгийн тохиромжтой вэ? гэсэн асуулт юм. Шапирогийн хариулт бол хууль ёст нь ёс суртахууны нэгдмэл байдалгүйгээр ч хамтын өөрөө удирдах тогтолцоог бий болгодог гэжээ.

9. Хууль ёсны үнэ цэн

Номын төгсгөлийн бүлгүүдэд Шапиро "хууль ёс" (legality) гэдэг зүйлийн ач холбогдлыг хамгаалж тайлбарлажээ. Түүний хэлж буйгаар хууль дээдлэх ёс нь нийтлэг төлөвлөлтийг тогтолцоожуулдаг (институц болгон тогтоодог) учраас л үнэ цэнтэй гэж үздэг. Ингэснээр хууль нь хүмүүсийн дунд санал зөрөлдөөн их байсан ч нийгмийг тогтвортой, урьдчилан таамаглаж болохуйц, хамтран ажиллах боломжтой болгодог байна.

Шапирогийн хувьд хуулийн үнэ цэн нь ёс суртахууны хувьд төгс төгөлдөр байхдаа биш, харин янз бүрийн үзэл бодолтой, олон ургалч нийгэмд хүмүүс хамтран ажиллах боломжийг бий болгоход оршдог. Энэ бодит нөхцөл байдалд тулгуурласан

тайлбар нь ёс суртахууны асуудал дээр санал зөрөхийг зайлшгүй зүйл гэж үздэг хүмүүсийн хувьд онцгой үнэмшилтэй байна.

Гэхдээ зарим асуултууд урган гарч ирж байна. Энэ үзэл нь шударга бус тогтолцоог төлөвлөлт нь сайн бол хууль ёсны мэт харагдуулах аюултай биш үү? Төлөвлөлтийн онолоор шударга бус хуулийг шүүмжлэх, засаж сайжруулах арга бий юу? Шапиро хууль ёс нь алдаа дутагдалтай системд ч гэсэн үнэ цэнтэй байж болох ч энэ нь эрх зүйн ёс суртахууны үнэлгээг үгүйсгэдэггүй гэдгийг тодотгосон байна.

Эцсийн дүндээ Хууль ёс ном нь хүмүүсийн санал зөрөлдөөн бодитой зүйл гэдгийг хүлээн зөвшөөрдөг бас тэд хэрхэн хамтран ажиллаж чаддаг болохыг үндэслэлтэй тайлбарласан байна.

10. Шапирогийн онолыг Монголын нөхцөлд буулгах нь

Хууль ёс номыг уншсаны дараа хамгийн сонирхолтой асуултуудын нэг бол Шапирогийн Төлөвлөлтийн Онол Монголын хууль эрх зүйн тулгамдсан асуудлууд болон боломжуудыг хэрхэн тодорхойлж болох вэ гэдэг юм. Монгол Улс нь бусад олон шилжилтийн үеийн ардчилсан орнуудын нэгэн адил сүүлийн хэдэн арван жилд хууль, эрх зүйн шинэчлэлийг хурдацтай хийсэн. Гэвч эрх зүйн тогтолцооны институцийн чадавх, хэрэгжилт, хууль ёсны байдалтай холбоотой асуудлууд одоо ч байсаар байна.

Шапирогийн гол санаа болох эрх зүй нь хүмүүсийн хоорондох хамтын ажиллагааны асуудлыг шийдэхийн тулд нийгмийн төлөвлөгөө боловсруулдаг систем гэдэг үзэл нь эдгээр асуудлыг ойлгоход маш чухал өнцөг болж чадна. Монголын хууль тогтоогчид, шүүх, засгийн газрын байгууллагууд бүгд төлөвлөгөө боловсруулдаг институциуд юм. Гэвч тэдний баталж буй хууль тогтоомж, дүрэм журам (тэдгээрийн төлөвлөгөөнүүд)-ын чанар, уялдаа холбоо нь харилцан адилгүй байна. Зарим хуулиудыг хангалттай хэлэлцэж зөвшилцөлгүйгээр, тодорхой бус, эсвэл хэрэгжүүлэх арга замгүйгээр баталдаг нь эргээд олон зөрчил, үл ойлголцол, эргэлзээг үүсгэж, олон нийтийн итгэлийг сулруулдаг.

Төлөвлөлтийн онолын үүднээс Монголын хууль, эрх зүйн шинэчлэл зөвхөн шинэ хуулиуд батлахаар зогсохгүй, харин маргаантай асуудлуудыг шийдвэрлэх чадвартай, сайн ойлгогдсон, олон нийтийн хүлээн зөвшөөрсөн төлөвлөгөөг боловсруулах, түгээх, хэрэгжүүлэх институцийн чадавхыг сайжруулах ёстой болно. Үүний тулд хуулийн боловсрол, шүүхийн хараат бус байдал, хууль батлах явцын ил тод байдал, төрийн байгууллагын хариуцлагыг сайжруулахад анхаарах шаардлагатай юм.

Үүнээс гадна Шапиро хуулийг хүмүүс хоорондоо санал зөрөлдсөн үед харилцан зохицуулах хэрэгсэл гэж үздэг нь Монголын олон янз байдалтай нийгмийн нөхцөлд онцгой тохиромжтой. Учир нь Монгол Улсад ялгаатай байдал бодит зүйл тул хууль нь бүх хүмүүсийг ижил ёс суртахууны зарчимд оруулах гэж оролдохгүйгээр өөр хоорондоо санал зөрөлдсөн ч тайван хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг байх шаардлагатай. Төлөвлөлтийн онолын үүднээс бол хууль нь гүн гүнзгий ёс суртахууны маргааныг эцэслэн шийдвэрлэх хэрэгсэл биш харин маргааныг шийдвэрлэж чаддаггүй нөхцөлд ч гэсэн тайван хамтын ажиллагааг хадгалах арга хэрэгсэл юм.

Гэхдээ энэ үзэл нь мөн өөрийн гэсэн эрсдэлийг дагуулж байна. Шапирогийн онолоор төлөвлөгөө нь шударга бус зорилгод ч ашиглагдах эрсдэлтэй. Учир нь төлөвлөлтийн онол нь эрх зүйн үүргийг тайлбарладаг боловч түүний ёс суртахууны үнэ цэнийг тодорхойлдоггүй. Монголын нөхцөлд энэ нь хууль тогтоомж, дүрэм журам нь

ардчилсан хяналттай байж, ёс суртахууны шүүмжлэлд нээлттэй байх ёстойг анхааруулж байна. Эс бөгөөс эрх мэдэлтнүүдийн дур зоргоороо авирлах хэрэгсэл болон хувирах эрсдэлтэй.

Эцсийн дүндээ Шапирогийн санааг Монголын нөхцөлд ашиглах нь хуулийг зөвхөн үр дүнтэй төлөвлөгөө байлгаад зогсохгүй, мөн иргэд оролцдог, ил тод, хариуцлагатай, нийгэмдээ үнэхээр харьяалагдсан хамтын төсөл болгон хөгжүүлэх шаардлагыг онцлох ч манай нөхцөлд ёс суртахууны хэм хэмжээ зарчмыг орхигдуулж болохгүй.

---oOo---

НОМЫН НЭЭЛТЭД ХЭЛЭХ ҮГ

Шихихутуг их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор (Ph.D), профессор Г.Амаржаргалан

Йелийн их сургуулийн профессор Скотт Шапирогийн “Хуульт ёс” бүтээлийн орчуулгын бүтээлийн нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирсэн эрхэм зочид, эрдэмтэн судлаачид, сургуулийн хамт олондоо энэ өдрийн мэндийг хүргэе.

Шихихутуг их сургууль эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд 4 дэх удаагаа стратегийн шинэчлэл хийн 2032 он хүртэлх зорилтуудаа тодорхойлсны дотор эрдэм шинжилгээний үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, энэ хүрээнд нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлэх тодорхой зорилтууд тавьсан.

Энэ хүрээнд хэд хэдэн бүтээлч ажил санаачилсны дотор дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлийг олон улсын зах зээлд гаргах, нөгөө талаар дэлхийн оюуны өв болсон бүтээлийг орчуулан олон нийтийн хүртээл болгох, судалгааны царааг нэмэгдүүлэх, энэ утгаараа нийгмийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах чин хүсэл, бүтээлч зорилго тавин ажиллаж байна.

Дэлхийн оюуны өв болох бүтээлийг орчуулан нийтийн хүртээл болгох санаачилгын хүрээнд өмнө нь хэд хэдэн судлаач, багш нарын бүтээлийг санхүүжүүлэн дэмжиж байсан бол албан ёсны төслийн санаачилгаар энэхүү бүтээлийг сонгон аваад байна.

28

Бүтээлийн тухайд, зохиогчийн тухайд манай орчуулагч, редактор, судлаач эрдэмтэд маань гүн утга, агуулгатай яриа өрнүүлэх байхаа. Бүтээлийг сонгож авахад нөлөөлсөн олон хүчин зүйлс байна. Харин номын нээлтийн үг төдийд товчхон хэдэн санааг хөндье.

Йелийн их сургуулийн профессор Скотт Шапирогийн “Хуульт ёс” хэмээх бүтээл нь зохиогчийн амьдралын зовлон жаргалтай хамт хэрхэн бүтээгдсэн талаар, үгийг нь утгатай, өгүүлбэрийг найруулгатай болгоход бусдын урмын үг, чин сэтгэл, хичээнгүй чанар хэрхэн нөлөөлсөн тухай номын удиртгал хэсэгт зохиогч дурдсан байдаг. Эрдэмтэн хүн, судлаач хүн аливаа нэг үгийг, өгүүлбэрийг өмчилж өөриймшүүлэхээс илүүтэйгээр бусдыг дэмжих, хүлээн зөвшөөрөх хэрэгсэл болгон өгөөмөр хандах үлгэр жишээг зохиогч энэ хэсэгт талархан өгүүлсэн мэт. Магадгүй нэг зохиогчийн оюуны бүтээл хэрхэн дэлхийн оюуны өв болохуйц үнэ цэнийг хадгалж байгаагийн нэг шалтгаан гэж харж болно.

Хууль зүйн шинжлэх ухааны сүүлийн үеийн бүтээлүүдэд аливаа нэг асуудлыг бүхэлд нь шийдвэрлэдэг нэг л онол, бүхэлд нь судалдаг нэг л арга зүй байх боломжгүйг олонтоо дурдах болсон. Энэ агуулгаар, судлаачдаас хэд хэдэн онолын, арга зүйн зохицол бүтээх чадвартай байх, энэ зохицлыг сэтгэлгээний дээд түвшинд боловруулдаг байх чадварыг шаарддаг болсон байна. Зохиогч бүтээлээрээ дээрх зохицлыг хэрхэн бүтээж болох үлгэр жишээ, үнэ цэнийг харуулсан гэж хэлж болно.

“Философийн үнэн”-г мэдэх тухай зохиогчийн логик дүгнэлтээр үндэсний эрх зүйг судлах уг суурь, итгэл үнэмшлийг олж авч болохоос гадна “эрх зүй” ба “хууль”, “жам ёсны эрх” ба “позитив эрх” тэр ч бүү хэл “хуульч” ба “философич” зэрэг утгын хамаарлаар тайлбарласан эрх зүйн сорилт, сонголт, сонирхолтой шийдлүүд нь судлаачдад, ялангуяа мета судлаачдад тулах хүч болно гэдэгт итгэлтэй байна.

Энэ мэтчилэн бүтээлийг сонгон авсан шалтгааныг, зохиогчийн, бүтээлийн үнэ цэнийг тоочоод баршгүй тул уншигчдадаа үлдээе.

Зохиогч бүтээлийн төгсгөл хэсгийг Йелийн их сургуульд багшилж байхдаа бичиж дуусгасан. Энэ талаар, “Йелд хичээл заахын нэг гайхамшигтай давуу тал нь эрдэм шинжилгээний ажлыг өндөр түвшинд дэмждэгт байв.” хэмээн онцолсон байдаг. Судлаачийн ур чадвараас гадна судалгаа хийх орчин, бүтээлч дэмжлэг, түгээн дэлгэрүүлэх санхүүжилт үнэхээрийн чухал. Эрдэмтэн судлаачид маань номын удиртгал хэсэгтээ ийм “талархлыг” бичдэг, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд судлаачдадаа ингэж үнэлэгддэг байгаасай гэж манай хамт олон чин сэтгэлээсээ хүсэж байна.

“Энэхүү бүтээлийг Шихихутуг их сургуулийн “Дэлхийн оюуны өвийг Монголд” санаачилгын санхүүжилтээр хэвлэв.” хэмээн бүтээлийн нүүр хэсэгт дурдсан. Энэ санаачилгыг эхлүүлэн дээрх бүтээлийг сонгон авч, Монгол хэл дээрх орчуулгын бүтээл болгон уншигч, судлаачдын гар дээр тавьж байгаагийн учир шалтгаан нь дээр дурдсан хамт олны минь чин хүсэлтэй холбоотойг хэлэхэд таатай байна.

Бид сургуулийнхаа эрхэм зорилгыг тодорхойлохдоо “нийгэмд сайн сайхныг түгээхэд” бүхий л үйл ажиллагаа чиглэгдэг байхыг зорьсон. Бидний дээрх санаачилга, хичээл зүтгэл нь дэлхийн болон Монголын эрдэмтдийн оюуны өв болох олон сайхан бүтээлүүдээр дамжин нийгэмд, оюун санаанд гэрэл нэмж, сайн сайхныг түгээн дэлгэрүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ их үйлсийн гэрч болж, өнөөдрийн арга хэмжээг хүндэтгэн хүрэлцэн ирсэн эрхэм зочид, эрдэмтэн, судлаачдадаа гүн талархал илэрхийлье. Санаачилга гаргасан профессор, дэмжсэн байгууллага, орчуулгын нөр их ажлын ард гарч, бүтээлийг зохиогчийн нэгэн адил мэдрэмжээр унших боломж өгсөн орчуулагч, редактор багш нартаа Шихихутуг их сургуулийн хамт олны нэрийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлэн орчуулгын бүтээлийг нийтийн хүртээл болгох хүндэтгэлийн арга хэмжээ нээснийг мэдэгдэж байна.

Бидний оюун санаа Дэлхийн оюуны өв болсон гайхамшигт бүтээлүүдээр үргэлж гэрэлтэж байхын ерөөлийг өргөө.

Та бүхэндээ баярлалаа.

---oOo---

НОМЫН МЯЛААЛГА ҮГ

*ДХИС-ийн зөвлөх профессор, доктор
(Ph.D), профессор Ч.Нямсүрэн*

Оросын эрдэмтэн С.С.Алексеев дэлхийн хууль зүйн шинжлэх ухаанд том хувь нэмэр оруулсан хүн. Тэрээр хэлэхдээ байгаль судлаачид байгаль гэж үгний талаар мэддэгүйтэй адил эрх зүйч, хуульч бид нар бас хэзээ ч эрх зүйн зүйн зүг чигийг нь олохгүй бололтой гэж хэлсэн байдаг.

Энэ бол аргагүй. Аливаа эрх зүйн сонгодог онолууд чинь дараа нь сонгодог бусын онол болсон. Одоо сонгодог бусын дараах онолын хэлбэрүүд гарч ирсэн. Үүний нэг илрэл бол Ж.Скотт Шаферогийн “Хууль ёс” хэмээх энэ ном мөн. Бид нар зөвхөн нөгөө жам ёсны эрх зүй, нормативизм, поститивизм болон социологийн онолоо яриад л сонгодог онолын хүрээнд л шарикдаад байдаг байсан. Гэтэл чинь сүүлийн үед сонгодог бус философи гарах болсон. Өөрөөр хэлбэл энэ аливаа үзэгдлийг таньж мэдэхдээ зөвхөн объектыг таньж мэдэх биш өгүүлэгч асуудлыг аль өнцөгөөс харж байна, өөрийх нь мэргэжлийн мэдлэг, ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил тусчихсан юм бишүү гэж анзаарах хэрэгтэй. Тухайлбал, урлаг гэхэд л сонгодог урлагийн дараа модернист урлаг гээд гараад ирсэн байх жишээтэй.

21 дүгээр зууны эхэн үеэс философийн, ялангуяа эрх зүйн онол чинь аливаа объектыг таньж мэдэхдээ субъектийн хандлагаар таньж мэдэхдээ дээрээс нь энэ яагаад бусдаас өөр байна гэдгийг судалдаг цоо шинэ хөгжлийн түвшинд гараад ирлээ шүү дээ. Энэ бол нөгөө хар нүхний онол, харьцангуй онол, квант физик, огторгуйн геометрийн онол гэх мэтийн онолуудтай зэрэгцээд л гарч байх жишээтэй. Энэ тохиолдолд эрх зүйн онолчид эрх зүйг интегратив (integrative) хандлагаар тайлбарладаг, шударга ёсны, энэрэнгүй ёсны тухай зарчмууд буюу нийгмийн үнэт зүйлсэд тулгуурлан хүн төрөлхтний төрт ёс, хууль цаазын түүхэнд бүтээсэн. цаашлаад археологийн талаас нь, ёс суртахуулаг байдал гээд янз бүрээр авч үзэх болсон.

Үүний дараа энэ Ж.Скотт Шаферогийн сургаал гарч ирсэн. Эрх зүйг тодорхойлохдоо бид зөвхөн хэм хэмжээний тогтолцоо гэж үздэггүй. Харин сайн төрийн ёсны зарчим, ёс суртахуун, түүхэн уламжлал, нийгмийн харилцааг зөв зохицуулах арга хэлбэрийн нэгдэл гэж ойлгодог. Үүнээс гадна эрх зүй нь инноваци, технологийн хөгжилтэй нягт холбоотой бөгөөд ирээдүйн төлөвлөлтийг шаарддаг.

Ялангуяа хиймэл оюун ухааны эрин үед эрх зүй шинэ сорилтуудтай тулгарч байна. Тухайлбал, хиймэл оюун ухаан эрх зүйн харилцааны субъект болж чадах эсэх, түүний үйлдлийн үр дагаварт хэн хариуцлага хүлээх вэ, зохиогчийн эрхийг хэрхэн зохицуулах вэ зэрэг асуудал эрх зүйн шинжлэх ухааны өмнө тавигдаж байна. Иймээс эрх зүй нь зөвхөн өнөөгийн бус, ирээдүйд үүсэх нийгмийн харилцааг урьдчилан харж, түүнд тохирсон зохицуулалтыг төлөвлөх шаардлагатай байдаг.

Ингэхээр энэ номын ач холбогдлыг олж харсан орчуулагч С.Энх-Амгалан, редактор Д.Лүндээжанцан багшдаа бас маш их талархалтай байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн онолын интегратив хандлагад төлөвлөлтийн онол нэн чухал байна шүү дээ. Энэ ном бол чухал ач холбогдолтой. Яг сонгодог бусын дараах онол шиг субъектийн хандлагаар хуулийг бид нар яагаад дагах ёстой юм. Хууль нийгэмд ямар хэрэгтэй юм. Хэрвээ хуулийн төлөвлөлтийн зохицуулалтгүйгээр гаж кэйс гараад ирвэл энийг хэрхэн яаж зохицуулах юм бэ гэдэг асуудлууд энд хүчтэй, онцгой тавигдсан байгаа. Ингэхээр энэ талаар судлах нь чухал.

Би тус бүтээлийг орос хэл дээр нь уншиж үзсэн. Гэхдээ харьцуулж бодоход орчуулгыг их гоё болсон байна. Г.Эрдэнэбаг доктор болон шавь нар минь уучлаарай, би та нарын тэр Дворкин нарыг чинь уншаад заримдаа монголоор ойлгодоггүй байхгүй юу. Гэтэл орос дээр уншихад тодорхой байж байдаг. Тийм ээ. Ингэхээрээ тэр хэлдэг тэр олон янзын үхрийн бөөр шиг орчуулагч нар хэрэггүй. Би хувьд аа дээрх бүтээлүүдээс цөөхөн эшлэл хийгээд явж байсан болохоос биш гүн гүнзгий утгаар нь шавь нартаа хэлж өгөөгүй.

Одоо энэ номын утгаар, ялангуяа тэр эрх зүйн инновацын асуудал тавигдахад ирээдүйн төлөвлөлтийн асуудал, нийгмийн харилцан төлөвлөлт, цаг тавихад болбол энэ нэг том цоорхойг нөхөж өгөх юм байна гэж боддог. Тийм ээ. Ингэхээрээ бид нар бол эрх зүйн тодорхойлолт нийгмийн төлөвлөлтөөр бүрэн бүтэн болох нь ээ.

Үнэнээ хэлэхэд бол бид нар чинь Их хурлын гишүүдийг сонгохдоо та тэр эрх зүйн үнэт зүйлс, агуулга, уламжлалт инновацыг шударга хууль болгож хувирга гэж сонгодог. Гэхдээ. Энэ хэдийн маань гаргасан хуулиуд эрх зүй биш шүү дээ. Би нэг юман дээр санал зөрөөтэй байдаг. Нэг хууль гараад ирэхэд дагаад эрх зүй бичдэг. Энэ эрх зүй гэдэг чинь үнэт зүйлсийн тогтолцоо байхгүй юу. Энэ ирээдүйн чиг хандлагыг цогт тодорхойлсон. Түрүүчийн хэлдгээр ирээдүйн философи, онолыг чигээр нь тодорхойлох нь парадигмыг тодорхойлох ёстой.

Эрх зүй хууль гаргахад хөтлөх ёсгүй. Энэ чинь үнэт зүйлс өөрчлөгдсөн тохиолдолд л өөрчлөгдөх ёстой. Зөвхөн хууль гарахад юу өөрчлөгдөх билээ? Хуулийн хэрэглээ л өөрчлөгдөх ёстой байхгүй юу. Гэтэл чинь манайхан дагаад л бичээд байдаг. Энэ чинь үнэт зүйлсийн тогтолцоо, зарчим, уламжлал, шинэчлэл. Өөрөөр хэлбэл энэ чинь инновац, төлөвлөлт гэсэн үг шүү дээ.

Ж.Скотт Шаферогийн онолын энэ үзэл санаа манайд бол тодорхой хэмжээгээр ойлгогдохгүй байсан. Нэг ийм бүхэл бүтэн цоорхойг нь нөхөж өгч, бид нар инновацыг төлөвлөж, нийгмийн төлөвлөлт, нийгмийн харилцаа, аж амьдралыг хамтдаа төлөвлөх явдал. Хуулийн тодорхойлолт бол түүнийг чинь эрх зүйн бол агуулга, хууль болох хэлбэр гэдэг агуулгаар явах ёстой шүү дээ. За мэдээж энэ нормативизм бол хууль тэнцүү эрх зүй биз. Тийм ээ. Тэгэхээрээ энэнээсээ салмаар байна.

Энэ бүтээл бол чухал аа. Би түрүүн ач холбогдлыг нь тэмдэглэсэн. Энэ бол эрх зүйн үнэт зүйлсийн тодорхойлолтыг нөхөж өгсөн. Инновац дүрийг авч хаяж оронд нь шинэчлэлийглэлийг авч хаяж. Энэ бол нийгмийн харилцааны төлөвлөлт гэж оруулах ёстой гэж үзэж байна гэдэг дээр маш их баяртай байна.

Эцэст нь та бүхэнд нэг зүйлийг онцлон хэлэхийг хүсэж байна. Номын эхний редакцыг анхааралтай уншиж үзээрэй. Тэнд тодорхой асуудлуудын талаар нэлээд гүнзгий эргэцүүлэл, тунгаан бодолт тусгагдсан байгаа. Энэ нь онолын суурь сэтгэлгээтэй судлаачид аливаа асуудалд хэрхэн хандаж, хэрхэн задлан шинжилж, дүгнэлт хийдгийн нэгэн жишээ юм. Ийм эргэцүүлэл, онолын сэтгэлгээ нь эрх зүйн судалгааны чанар, үнэ цэнийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.

Ер нь аливаа эрх зүйн бүтээл, тухайлбал эрүүгийн эрх зүйн чиглэлийн ном, судалгааг уншихдаа зөвхөн өөрийн салбар, байгууллагын ашиг сонирхлын хүрээнд явцуугаар ойлгож болохгүй. Жишээлбэл, тухайн асуудал цагдаад хамаатай эсэх, эсвэл зөвхөн тодорхой субьекттэй холбоотой эсэхээр хязгаарлаж харах бус, эрх зүйт төрийн үнэт зүйл, эрх зүйн сэтгэлгээний өргөн хүрээнд авч үзэх нь чухал юм.

Хуульч хүний хувьд уншиж, эргэцүүлж, дахин дахин тунгаах ёстой бүтээлүүд байдаг. Ийм бүтээлүүд нь зөвхөн мэдлэг өгөхөөс гадна эрх зүйн сэтгэлгээ, хууль зүйн соёлыг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг.

Тиймээс энэхүү үнэ цэнтэй бүтээлийг эх хэлнээ хөрвүүлж, зохиогчийн зөвшөөрлийг авч, хэвлэн нийтлэхэд хүчин зүтгэсэн орчуулагчид, редакторууд болон энэхүү ажлыг дэмжиж ажилласан бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн энэ хамт олонтой олон жилийн өмнөөс ажил, амьдралын холбоотой явж ирсний хувьд шинэ орчин, шинэ бүрэлдэхүүнтэй нь дахин уулзаж байгаадаа баяртай байна. Та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баярлалаа.